




**УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ,  
ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРТ  
ИРГЭДИЙН САНАЛ АВАХ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА**



**2022 ОН**



## ТАНИЛЦУУЛГА

### Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Алсын хараа 2050-ын 9-р зорилго нь Улаанбаатар хотыг хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх,

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн орон зайн оновчтой төлөвлөлт бүхий зорилгод үндэслэх

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийг тодорхойлох

### Монгол Улсын Засгийн газрын 2020 – 2024 оны хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх

Засгийн газрын 248-р тогтоол батлагдсан

Зорилго нь замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгох

Үүнийг хэрэгжүүлэх Үндэсний хороог шуурхай зохион байгуулсан

### Улаанбаатар хотын хүн амын өсөлт сүүлийн 20 жилийн байдлаар

Хүн амын хөдөөгөөс хотруу шилжсэн суурьшил хөдөлгөөн эрчимтэй явагдсан

Улаанбаатар хотын хүн амын тоо 2000 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн

Нийслэлийн хүн амын тоо 2020 оны байдлаар 1,524,795 болж өссөн

Улсын хүн амын өсөлт дунджаар 1.7% өссөн бол Улаанбаатар хотын хүн ам 3.6%-аар өссөн

### Улаанбаатар хотын хүн амын өсөлтийг дагасан тээврийн хэрэгслийн өсөлт

Тээврийн хэрэгсэл 2000 онтой харьцуулбал даруй 14 дахин нэмэгдэж жилд дунджаар 15%-р өссөн

2020 оны байдлаар 604,518 тээврийн хэрэгсэл Улаанбаатар хотод бүртгэлтэй байна

Эдгээрийн 79.1% нь 10 жилээс дээш насжилттай



## ТҮГЖРЭЛИЙГ ҮҮСГЭЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

Улаанбаатар хотын замын хөдөлгөөний болон түгжрэлийн нөхцөл байдалд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлүүд нь доорх дөрвөн хэсэгт хуваагдаж байна.

1. Улаанбаатар хотод 2000 оноос хойш хийгдсэн хот төлөвлөлтийн байдал

2. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний зохион байгуулалт

3. Улаанбаатар хотын нийтийн тээвэр, парк шинэчлэлтийн удаашрал

4. Иргэдийн замын хөдөлгөөн зохион байгуулалт болон түүнтэй холбоотой хууль дүрмийг мөрдөж буй байдал

**“1. УЛААНБААТАР ХОТОД 2000 ОНООС  
ХОЙШ ХИЙГДСЭН ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
БАЙДАЛ”**



## 1. Улаанбаатар хотод 2000 оноос хойш хийгдсэн хот төлөвлөлтийн байдал

Иргэдийн явган алхах, унадаг дугуй унах зэрэг тэдэнд идэвхтэй хөдөлгөөн хийх дэд бүтцийн сүлжээ хангалттай хөгжөөгүй

Төлөвлөлтгүй газар олголт үүнийг дагасан барилгажилт болон хотын төв чиглэсэн хэт төвлөрлийг бий болгосон

- Хотын төвийн сургуулиудын анги дүүргэлтийн дунджаар 59.1%-ийг хамран сургах тойргийн бус сурагч эзэлдэг.
- Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоогүй байдлын улмаас шинээр баригдаж буй барилга байгууламжууд авто машины зогсоолгүй, явган зам, гарц орцгүй, хэт төвлөрлөрсөн байдал нь хотын түгжрэлд нөлөөлж байна.

Төрийн өмчийн 414

Эрүүл мэндийн 40

Ерөнхий боловсролын сургууль 59

Улаанбаатар хотын төвд байрладаг байгууллагууд

Худалдааны төвүүд 20

Их дээд сургууль 19

Хувийн хэвшлийн 18,507 байгууллага үйл ажиллагаа явуулдаг ба нийт ажлын байрны 70%-г бүрдүүлдэг.




# УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД

## ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Олон төвт хотын тогтолцоо

Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Зах, худалдааны төвүүдийн төвлөрлийг багасгах



440.3  
ГА



82,734  
ХҮН

БАЯНГОЛ ДҮҮРЭГ /11.2 га/

- "Бичил хороолол" олон нийтийн төв

ХАН-УУЛ ДҮҮРЭГ /12 га/

- "Нисэх" олон нийтийн төв

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ /14.5 га/

- "Хайлааст" олон нийтийн төв

БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ /163.6 га/

- "Амгалан" дэд төв
- "Дарь-Эх" олон нийтийн төв
- "Монел" олон нийтийн төв
- "Ургах наран" олон нийтийн төв

СОНГИНОХАЙРХАН

ДҮҮРЭГ /239 га/

- "Сонсголон" дэд төв
- "Шинэ төв" дэд төв
- "Тахилт" олон нийтийн төв



ХОТЫН ТӨВ



ХЭРЭГЖИЖ БАЙГАА  
ДЭД ТӨВ



ХЭРЭГЖИЖ БАЙГАА  
ОЛОН НИЙТИЙН ТӨВ



ШИНЭЭР  
ХИЙГДЭХ ДЭД ТӨВ



ШИНЭЭР ХИЙГДЭХ  
ОЛОН НИЙТИЙН ТӨВ

10 байршлын техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), барилгажилтын төсөл 2021-2022 онд хийгдэж байна.



## УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГО

### ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Олон төвт хотын  
тогтолцоо

Сургууль,  
цэцэрлэгийн  
хүртээмжийг  
нэмэгдүүлэх

Зах худалдааны  
төвүүдийн  
төвлөрлийг багасгах

### АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭГ ӨРГӨТГӨХ

Гол болон туслах  
замын сүлжээг  
сайжруулах

Авто зогсоолын  
менежментийг  
нэвтрүүлэх

Явган болон дугуйн  
замын сүлжээг  
нэмэгдүүлэх

### ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО ХЭМЖЭЭГ ЗОХИЦУУЛАХ

Авто машины  
импортын тоонд  
зохицуулалт хийх

Зорчилт хөдөлгөөний  
менежментийг  
хэрэгжүүлэх

Замын хөдөлгөөний  
аюулгүй байдал,  
соёлыг дээшлүүлэх

Замын хөдөлгөөний  
удирдлагын ухаалаг  
системийг нэвтрүүлэх

### НИЙТИЙН ТЭЭВРИЙГ САЙЖРУУЛАХ

Багтаамж ихтэй  
нийтийн тээврийн  
шинэ төрөл LRT  
нэвтрүүлэх

Нийтийн тээврийн  
чиглэлийн сүлжээ  
төлөвлөлтийг  
сайжруулах

Нийтийн тээврийн  
парк шинэчлэлт хийх

## **“2. УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ”**





## 2. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний зохион байгуулалт

Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх ажил сүүлийн жилүүдэд харьцангуй өргөн хүрээнд хийгдэж байгаа хэдий ч **1970 оноос хойш шинээр гол замуудыг барьж байгуулаагүй нь одоогийн хэвтээ, болон босоо тэнхлэгийн гол замууд ачааллаа дийлэхгүй хэмжээнд хүргэсэн.**

Мөн хотын **туслах гудамж замын сүлжээний торлог байдал дутуу, хоорондын холбогдох байдал хангалтгүй, томоохон гудамж замуудад сүлжээний нарийсалт ихтэй, уулзваруудын нэвтрүүлэх чадвар харилцан адилгүй, хэвтээ коридорыг холбосон босоо чиглэлийн гүүр, хөндлөн гарц, нүхэн гарц хангалтгүй, автомашины зогсоолын хүртээмж хангалтгүй** зэрэг нь түгжрэлийг бий болгох нэг гол шалтгаан болж байна.

**Уулзварын сайжруулалт, шинэ уулзварын хөдөлгөөн зохицуулалтын тэмдэг, тэмдэглэгээ тодорхой биш,** алдаатай байх зэргээр жолоочийг будлиулах, үл ойлголцол үүсгэх нөхцөл үүсгэж байна. Хотын төв зам дагуу 7км орчим хэсэгт автобусны давуу эрхтэй эгнээ байдаг ч мөрдөх байдал хангалтгүй тул нийтийн тээврийн үйлчилгээ давуу эрхтэй байх чиг үүрэг нь алдагдсан.




## УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД

### АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

Гол, туслах гудамж  
замын сүлжээг  
сайжруулах

Авто зогсоолын  
менежментийг  
нэвтрүүлэх

Явган хүний болон  
дугуйн замын  
сүлжээг  
нэмэгдүүлэх



- Нийт 22 ажлаас 21 ажил нь тендерийн шатанд явагдаж байна.
- Уулзварын дахин инженерчлэл болон явган, дугуйн замын зургийн ажил дуусмагц шууд гэрээгээр хийгдэхээр төлөвлөгдөж байна.

	Гол зам <b>11.47 км</b>
	Туслах зам <b>15.48 км</b>
	Уулзвар <b>18</b> байршилд
	Гүүр <b>5</b> гүүр
	Явган хүний зам <b>93 900 м<sup>2</sup></b>
	Дугуйн зам <b>30 км</b>

# “3. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТЭЭВЭР”



### 3. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТЭЭВЭР

- Нийтийн тээврийн үндсэн чиглэлийн 2042 км урт сүлжээтэй
- 89 чиглэлд автобус, троллэйбус үйлчилгээ үзүүлдэг
- 19 компани 980 орчим тээврийн хэрэгсэлтэйгээр иргэдэд үйлчилдэг
- Захын хорооллуудад нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал

- Нийтийн тээврийн үйлчилгээний одоогийн чиглэлүүд нь давхцал ихтэй
- Нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийгдээгүй
- Нийт автобусны 85% нь хуучин
- Тохижилт ая тухгүй байдлаас болон иргэд нийтийн тээврийг сонгон үйлчлүүлэх сонирхол буурч хувийн тээврийн хэрэгслийг илүүд үзэх болсон

- Нийтийн тээврээр үйлчлүүлдэг зорчигчийн тоо 2010 оноос жил бүр эрчимтэй нэмэгдэж 2014 онд 285 сая зорчигч болж нэмэгдэж байсан ч энэ тоо 2015 оноос хойш тасралтгүй буурсан
- 2021 онд 146 сая болж буурсан
- Хувийн тээврийн хэрэгслийн тоо 2021 онд 658 мянга болж өссөн




## УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД

### НИЙТИЙН ТЭЭВРИЙГ САЙЖРУУЛАХ

Багтаамж ихтэй  
нийтийн тээвийн шинэ  
төрөл LRT нэвтрүүлэх

Нийтийн тээврийн  
сүлжээ төлөвлөлтийг  
сайжруулах

Нийтийн тээврийн  
парк шинэчлэлт хийх



- Улаанбаатар хотын нийтийн тээврийн чиглэлийн давхцлыг бууруулах, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах зорилгоор сүлжээ төлөвлөлтийг оновчлох судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна.

**“4. Иргэдийн хөдөлгөөн зохион  
байгуулалт болон түүнтэй холбоотой  
хууль дүрмийг мөрдөх байдал”**



#### 4. ИРГЭДИЙН ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ДҮРМИЙГ МӨРДӨХ БАЙДАЛ

Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй жолоочийн “Замын хөдөлгөөний дүрэм” мөрдөх, хөдөлгөөнд соёлтой оролцох зан байдал төлөвшөөгүйгээс осол, аваар гаргах улмаар зам дээр олон цагаар түгжрэл үүсгэх шалтгаан болж байна.

Жил бүр

- 60 мянган жолооч шинээр бэлтгэгдэж
- 30 мянган жолооч эрхээ хасуулж
- Мөн тооны жолооч эрхээ сэргээлгэж байна

Дүрэм зөрчиж гудамж замын зорчих эгнээнд автомашин тавих тохиолдол түгээмэл байдаг.

Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөний дүрэм зөрчсөнтэй холбоотой торгуулийн арга хэмжээг гүйцэтгүүлсэн байдал 45%-тай байгаа нь жолоочийн замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх байдлыг сулруулж байна.



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

